



“ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ”

ОЛОН УЛСЫН ХУРАЛ

Огноо: 2025 оны 5-р сарын 22-23 өдөр

Байршил: Улаанбаатар, Монгол Улс

Ерөнхий мэдээлэл

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дэлхий нийтэд байгалийн гамшгийн давтамж эрс нэмэгдэж, улс орнуудад нийгэм-эдийн засгийн тогтворгүй байдал удаан хугацаагаар үргэлжлэх төлөв ажиглагдаж байна. Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй өсөн нэмэгдэж байгаа ган, зудын гамшиг, түүний үр дагавраар малчдын амьжиргаа доройтож, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, ядуурал, ажилгүйдэл, орчны бохирдол нэмэгдэж, олон талт ялгаварлан гадуурхалт бий болж байгаа ба хөдөөгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнууд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд илүү өртөмтгий, эмзэг болох нь харагдсан. Жендэрийн тэгш бус байдал, жендэр ба уур амьсгалын өөрчлөлтийн холбоо хамаарлын талаар олон нийтийн мэдлэг, ойлголт дутмаг, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгаа нь жендэрийн тэгш бус байдал гүнзгийрэх, эмэгтэйчүүдийн орлого олох боломж буурах, зэрэг үр дагавар авчирч байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (УАӨСК)-ын Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан тайланд гишүүн орнуудын 85 хувь нь хамгийн сүүлд гаргасан уур амьсгалын тайлан, илтгэлүүдэд жендэрийн тэгш байдлын талаар дурдсан бөгөөд энэ үзүүлэлтээр хөгжиж буй орнууд тэргүүлж байна (UN Climate Change Secretariat, 2024). Тухайлбал, Энэтхэг, Гватемал, Фижи, Канад улс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегид (UNFCCC, 2023), харин Филиппин (Environmental Management Bureau of the Republic of the Philippines, 2009) болон Кени (The National Council for Law reporting of Republic of Kenya, 2023) улсын уур амьсгалын өөрчлөлтийн тухай бодлогын баримт бичгүүдэд жендэрийн асуудлыг тусгажээ. Түүнчлэн УАӨСК-ийн Талуудын ХХХХ бага хурал (COP29)-ын үеэр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөллийг сааруулах чиглэлд авах арга хэмжээ, төлөвлөгөө болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд жендэрийн эрх тэгш байдлыг бэхжүүлэхийн тулд хүчин чармайлт гаргах шаардлагатайг онцолжээ. Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын олон баримт бичигт жендэрийн тэгш байдлын үндсэн ойлголтыг тусгасан хэдий ч ихэнхдээ насны бүлэг, нийгмийн давхарга, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээл, ядуурал зэрэг хүчин зүйлстэй төдийлөн сайн уялдуулаагүй байдаг.

Улс орны уур амьсгалын эмзэг байдлыг шийдвэрлэхэд үндэсний хэмжээний бодлого, стратеги, төсөвлөлтөд (Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө) жендэрийн үзэл баримтлалыг тусгах, нийгэм-эдийн засгийн салбаруудад тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг жендэрийн мэдрэмжтэй тодорхойлох, тогтвортой, эдийн засгийн үр ашигтай технологи нэвтрүүлэх, орон нутгийн түвшинд хувийн хэвшлийн оролцоог дэмжих асуудлууд чухал юм.

Монгол Улс сүүлийн 10 жилд тухайлсан салбар болон орон нутгийн түвшний бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн асуудлыг тусгах талаар багагүй ахиц гарган ажиллаж байна. Цаашид жендэрийн тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд оролцогч талуудын анхаарлыг хандуулах, асуудлыг хэлэлцэх, улмаар түнш орнууд болон хөгжлийн байгууллагуудтай хамтран “Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах тухай НҮБ-ын тогтоол”, мөн бүс нутаг болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, уур

амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чухал үүрэг гүйцэтгэсэн “Улаанбаатарын тунхаглал”-ын хүрээнд өгсөн санаачилга, үүрэг амлалтаа бататгах цаг нь ирээд байна (МУЗГ, 2018). Түүнчлэн, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо 2024 онд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт нь ногоон ирээдүйн төлөө сэдвийн дор чуулж, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын доройтол, орчны бохирдлын асуудлыг хэлэлцсэн билээ.

Даян дэлхийн охид эмэгтэйчүүд нийгмийн бүхий л харилцаанд эрх тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэх талаар дуу хоолойгоо нэгтгэн 1995 онд БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулсан Дэлхийн эмэгтэйчүүдийн IV бага хурлаар баталсан “Бээжингийн тунхаглал” болон “Үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсний 30 жилийн ой тохиож буйг тэмдэглэж, олон улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангахад оруулсан энэхүү баримт бичгийн түүхэн хувь нэмрийг онцолж байна.

Иймд Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ), Жендэрийн Үндэсний хороо (ЖҮХ), Азийн Хөгжлийн Банк (АХБ) хамтран “Жендэрийн тэгш байдал ба Уур амьсгалын өөрчлөлт” сэдэвт олон улсын хурлыг АХБ-ны техникийн туслалцааны хүрээнд (ЖҮХ, АХБ, 2024) Монгол Улсад Жендэрийн үндэсний хороо байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж байна. Хурлыг “Биологийн олон янз байдлыг хамгаалах” олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулж байгаа нь биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдал хэмээх гурван талт асуудлыг уялдаа холбоотой шийдвэрлэхэд чиглэсэн, өндөр ач холбогдолтой хурал болохыг илтгэнэ. Түүнчлэн, энэхүү хурал нь Монгол Улсад 2026 онд зохион байгуулагдах Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын Талуудын XVII бага хурлыг угтаж буй арга хэмжээ юм.

Уг хурал нь (i) Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх санаачилгад жендэрийн үзэл баримтлалыг тусгасан шилдэг туршлагыг түгээх; (ii) Уур амьсгалын өөрчлөлтийн жендэрийн ялгаатай нөлөөллийн талаар ойлголтыг бэхжүүлэх, эмэгтэйчүүдийн үүргийг тодотгох, инновац (шинэ санаа)-ыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; (iii) Жендэрийн талаар Тогтвортой Хөгжлийн Зорилт 5 (ТХЗ 5), уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах Тогтвортой Хөгжлийн Зорилт 13 (ТХЗ 13), хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх Тогтвортой Хөгжлийн Зорилт 17 (ТХЗ 17) болон түүнийг хэрэгжүүлэх шинэ хөтөлбөрүүдийг дэмжих; олон улсын хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтуудад хувь нэмэр оруулахуйц нэн чухал ач холбогдолтой юм.

Зорилго:

- (i) Бүс нутгийн болон дэлхий дахины жендэрийн тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт хоорондын хамаарлын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, уур амьсгалын бодлого, хэрэгжилт, санхүүжилтэд тулгарч буй сорилт, сайн туршлага, шинэлэг санаачилгуудын талаар улс орнууд хоорондын мэдлэгийн солилцоог өрнүүлэх;
- (ii) Бүс нутгийн болон олон улсын түвшинд амжилттай хэрэгжиж буй стратеги, механизм, нөөц боломжийг хуваалцаж, уур амьсгалын өөрчлөлт болон жендэрийн тэгш бус байдлыг шийдвэрлэх хамтын чадавхыг нэмэгдүүлэх;
- (iii) Жендэрийн хариуцлагатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй бодлого боловсруулах, мөн орон нутгийн санаачилгуудыг дэмжих зорилгоор хэлэлцүүлгийн хүрээнд гарсан үр дүн, саналуудад үндэслэсэн цогц зөвлөмж бүхий Уриалга гаргах.

Хурлаас гарах үр дүн

Олон улсын хурлыг угтан Монгол Улсад 27 удаагийн цахим болон танхимын урьдчилсан зөвлөлдөх уулзалтыг холбогдох салбарын төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид, иргэдийг оролцуулан зохион байгуулна. Зөвлөлдөх уулзалтаас гарсан гол хэлэлцүүлэг, саналууд нь олон улсын хурлын гол үр дүн

болох нийтлэг асуудал, сорилт бэрхшээлийг шийдвэрлэх цогц зөвлөмж бүхий Уриалгад тусгагдана. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газарт болон олон улсын хуралд оролцогч улс орнуудын төлөөлөлд тус уриалгыг хэрэгжүүлэхэд хүчээ нэгтгэн, хамтран ажиллахыг санал болгоно.

Хурлын бүтэц, зохион байгуулалт

Олон улсын хурал нь нэгдсэн хуралдаан болон сэдэвчилсэн дөрвөн салбар хуралдаанаас бүрдэнэ.

Нэгдсэн хуралдааны панел хэлэлцүүлэг нь жендэрийн эрх тэгш байдал болон уур амьсгалын өөрчлөлтийн холбоо хамаарлын хүрээнд шинээр гарч буй асуудлуудыг шийдвэрлэж буй туршлагыг хуваалцах, цаашид авч хэрэгжүүлж болох хамгийн оновчтой арга замыг тодорхойлоход чиглэнэ.

Сэдэвчилсэн салбар хуралдаанууд нь тухайн сэдвийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлж буй олон улсын сайн туршлага солилцож, уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх бодитой алхмуудыг хамтран тодорхойлоход чиглэнэ.

Сэдэвчилсэн хуралдаан 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн жендэрийн хариуцлагатай бодлого

НҮБ-ын УАӨСК-д зааснаар улс орон бүр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтыг хэрэгжүүлэхдээ жендэрийн хариуцлагатай байх зарчмыг баримтлах тухай заасан. Тус конвенцтой нийцүүлэн гаргасан “Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө” (UNFCCC, 2019) нь уур амьсгалын бодлогод жендэрийн асуудлыг тусгах, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлд олон нийтэд түшиглэсэн олон арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж байна. Үүнд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (ADAPT) төслийг дурдаж болно. Энэхүү салбар хуралдаан нь уур амьсгалын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн хүрээнд улс орнуудын авч хэрэгжүүлж буй шийдэл, сайн туршлага, аргачлалын талаар мэдлэг хуваалцахад чиглэх юм.

Сэдэвчилсэн хуралдаан 2. Хөдөөгийн хүн амын аж байдлыг сайжруулах, жендэрийн хариуцлагатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мэдлэгийн платформ бий болгох

Дэлхийн нийт хүн амын 43 хувь буюу 3 тэрбум гаруй хүн хөдөө орон нутагт амьдарч буй бөгөөд үүний 80 орчим хувь нь нэн ядууд тооцогдож байна (World Bank, 2022). Хөдөө аж ахуйн салбарт ажилладаг хүн амын бүлэг тэр дундаа эмзэг бүлгийнхэн санхүүгийн чадамж сул байдгаас хүнсний аюулгүй байдал алдагдах, усны хомсдол, ядуурал зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд илүү өртөмтгий байдаг. Үүнтэй зэрэгцэн нийгмийн зарим уламжлалт хандлага нь эмэгтэйчүүдийн үл хөдлөх хөрөнгө, газар, мал зэрэг аливаа өмч эзэмших эрхийг нь хязгаарладаг тул тэдний уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах чадамжийг улам бүр сулруулж байдаг. Үүнээс гадна сэтгэцийн эрүүл мэндийн өөрчлөлт, хэт халалтаас үүдэлтэй өвчлөл зэрэг эрүүл мэндийн асуудалд эмэгтэйчүүд илүү өртдөг. 2015 оноос хойш дэлхий даяар ногоон ажлын байранд шилжсэн тохиолдлын 66 хувь нь эрэгтэйчүүд байсан (Linkedin Economic Graph, 2023) ба энэ чиглэлд эмэгтэйчүүдийг дэмжих шаардлагатай нь харагдаж байна. Түүнчлэн эрэгтэйчүүд ч уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдсэн байгалийн гамшгийн хохирогч болсоор ирснийг Монгол Улсад сүүлийн үед хийгдэж буй судалгаануудад дурджээ. Өөрөөр хэлбэл, Монголын уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг өв залгамжлан эрхэлж ирсэн хөдөөгийн эрэгтэйчүүд зудын гамшигт өртсөний дараа эдийн засаг, эрүүл мэндийн хувьд маш том хохирол амсаж байгаа нь гэр бүлийн харилцаа, сайн сайхан

байдалд сөргөөр нөлөөлдөг аж. Энэхүү салбар хуралдаанаар хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний тэгш бус хүртээмж, гэр бүлийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан байгалийн гамшгийн дараах нийгмийн олон талт цогц асуудлууд хийгээд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд болон бусад бүлгүүд эдгээр хямралыг хэрхэн даван туулж буй талаар ярилцах юм. Мөн ногоон технологид суурилсан ногоон ажлын байр, ногоон ур чадвар зэрэг хөдөө аж ахуй дахь эдийн засгийн тэгш хүртээмжийг бий болгох, хөдөөгийн хүн амын аж байдлыг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон уламжлалт аж ахуйг хөгжүүлэхэд чиглэсэн мэдлэгийн платформ бий болгох шийдэл, боломжийн талаар хэлэлцэнэ.

Сэдэвчилсэн хуралдаан 3. Жендэрийн хариуцлагатай уур амьсгалын санхүүжилт

Нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлаас шалтгаалан ялангуяа хөгжиж буй орнуудад эмзэг бүлгийн иргэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд илүү өртөмтгий байдаг. Түүнчлэн мал аж ахуй, газар тариалан зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн шууд нөлөөнд өртдөг салбаруудад олноор ажиллаж байдаг энэхүү бүлэгт зорилтот дэмжлэг нэн шаардлагатай байна. Иймд эмзэг бүлгийн иргэдийн өдөр тутмын амьдралд бодитой дэмжлэг болох сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд төрийн, олон улсын болон хувийн сангуудаас бүрдэх уур амьсгалын санхүүжилтийг чиглүүлэх нь чухал юм. Мөн бичил, жижиг бизнес эрхлэгчдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байгааг анхаарч аливаа эрсдэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор эмэгтэй эзэмшигчтэй хувийн хэвшлийн чадавхыг бэхжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эмэгтэйчүүдийг уур амьсгалын санхүүжилтийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд татан оролцуулах, ногоон хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай. Энэхүү салбар хуралдаан нь жендэрийн мэдрэмжтэй уур амьсгалын санхүүжилтийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж буй шийдэл, сайн туршлагын талаар мэдлэг солилцоход чиглэнэ.

Сэдэвчилсэн хуралдаан 4. Эмэгтэйчүүдийн манлайллын чадамж, уур амьсгалын өөрчлөлтийн талаар гаргасан санаачилга

Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, түүнд дасан зохицоход охид, эмэгтэйчүүдийн манлайлал болон оролцоо нэн чухал. Эмэгтэйчүүд гол төлөв гэр бүл, үр хүүхэд, ойр дотны хүмүүс, хамт олноо асран хамгаалах үүрэгтэй байдаг. Тэд хүнсний аюулгүй байдал, эрчим хүч, цэвэр усны хүртээмж зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой, эрүүл мэндэд чухал нөлөөтэй асуудлыг зохицуулахад гол үүрэг гүйцэтгэдэг. Мөн эмэгтэйчүүд зөв дадлыг үр хүүхдэдээ өвлүүлэх, байгалийн нөөцийг зохистой ашиглах, байгаль хамгаалахад ихээхэн хувь нэмэр оруулж байдаг. Тиймээс бүс нутгийн болон үндэсний түвшний шийдвэр гаргалтад эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь аливаа эерэг өөрчлөлтийг идэвхтэй түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлэх тул энэхүү салбар хуралдаанаар эмэгтэйчүүдийн манлайллаар бий болсон санал санаачилга, туршлагуудыг хуваалцахад чиглэнэ.

Хуралд оролцогчид

Олон улсын хуралд нийт 150 төлөөлөгч, үүнээс 60 төлөөлөгч нь Ази, Америк, Европ, Австрали тивийн арав орчим улсаас оролцохоор төлөвлөж байна. Оролцогчид нь засгийн газрын шийдвэр гаргагчид, дипломат корпус, олон улсын байгууллага, олон талт хөгжлийн банк, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, мөн жендэрийн болон уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Үүнд: (а) Монгол Улсын Засгийн газрын төлөөлөл (Ерөнхий сайдын ажлын алба, ЖҮХ, БОУАӨЯ, Гадаад харилцааны яам, ХХААХҮЯ г.м) (б) НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудын төлөөлөл/захирал (в) АХБ-ны төлөөлөл, (г) Уур амьсгалын ногоон сангийн төлөөлөл, (д) олон улсын шинжээч судлаач, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, /е/ дипломат корпус, /ё/ Аймаг, нийслэлийн төлөөлөл, /ж/ Монгол

Улсын төрийн бус, иргэний нийгэм, эрдэмтэн судлаач, хувийн хэвшлийн төлөөлөл зэрэг багтана.



**“ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ”
ОЛОН УЛСЫН ХУРАЛ**

ХӨТӨЛБӨР

2025 оны 5 дугаар сарын 22, Пүрэв гараг. Шангри-ла Улаанбаатар, Их танхим.

Хугацаа	Үйл ажиллагаа
08:00 – 09:00	Бүртгэл
09:00 – 09:40	Нээлтийн үг <ul style="list-style-type: none">Монгол Улсын Ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хорооны дарга Лувсаннамсрайн Оюун-ЭрдэнэАзийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Шэннон Коулин Мэндчилгээ <ul style="list-style-type: none">Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэндчилгээ (Ерөнхийлөгчийн зөвлөх Баярсайханы Жавхлан)Монгол Улсын Их Хурлын Даргын мэндчилгээ (УИХ-ын гишүүн Болдын Уянга)НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Амина Мохаммед /видео мэндчилгээ/
09:40 – 10:20	Үндсэн илтгэл <p><i>“Уур амьсгалын өөрчлөлт ба жендэрийн тэгш эрхийн уялдаа холбооны дэлхийн болон үндэсний чиг хандлагууд”</i></p> <ul style="list-style-type: none">Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Салдангийн Одонтуяа (20 мин)Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд бөгөөд Төлөөлөгчийн газрын тэргүүн Ина Марчюлөните (20 мин)
10:20 – 10:30	Дурсгалын зураг
10:30 – 11:00	Цайны завсарлага
НЭГДСЭН ХУРАЛДААН	

11:00 – 12:20	<p>Нэгдсэн хуралдаан</p> <p><i>“Жендэрийн хариуцлагатай, уур амьсгалын санаачилгыг ахиулах нь: Дэлхийн, бүсийн, үндэсний түвшинд авч хэрэгжүүлж буй бодлого, тэргүүлэх чиглэл, үйл ажиллагаа”</i></p> <p>Зочин оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр • Азийн Хөгжлийн Банкны Зүүн Азийн бүсийн үйл ажиллагаа хариуцсан дарга Балабхаскара Рэдди Батхула • Бүгд Найрамдах Коста Рика Улсын Эмэгтэйчүүдийн аж байдлын сайд Синди Кесада Эрнандез (хэлэлцэж шийдвэрлэх) • БНХАУ-ын Экологи, байгаль орчны яамны дэргэдэх Уур амьсгалын өөрчлөлтийн стратеги, олон улсын хамтын ажиллагааны үндэсний төв, Др. Лян Мэйцун • Олон улсын хараат бус жендэрийн шинжээч Дарьсүрэнгийн Амарсанаа <p>Чиглүүлэгч: НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн газрын Жендэр, уур амьсгалын өөрчлөлтийн бүсийн хөтөлбөрийн мэргэжилтэн Эми Рэжжерс</p>
12:20 – 13:30	Үдийн хоол
ЗЭРЭГЦЭЭ ХУРАЛДААН 1: (Сэдэвчилсэн хуралдаан 1, 2 зэрэг явагдана)	
Сэдэвчилсэн хуралдаан 1: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулахад чиглэсэн жендэрийн хариуцлагатай бодлого	
13:30 – 13:40	<p>Нээлтийн үг</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд, Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын Талуудын 17 дугаар бага хурал (COP17)-ын Бэлтгэл ажлын албаны дарга Наваан-Юндэнгийн Чимгүүндарь
13:40 – 14:10	<p>Үндсэн илтгэл</p> <ul style="list-style-type: none"> • Азийн Хөгжлийн Банкны Жендэрийн албаны Нийгмийн хөгжил, жендэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Зонибел Вудс

14:10 – 15:10	<p>“Олон нийт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлд улс орнуудын авч хэрэгжүүлж буй жендэрийн хариуцлагатай бодлогын шийдэл, арга зам”</p> <ul style="list-style-type: none"> • Богино хэмжээний бичлэг (3 мин) <p>Зочин оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын дарга, хурандаа Дэмбэрэлийн Баасансүрэн • Бүгд Найрамдах Солонгос Улсын Эмэгтэйчүүдийн хөгжлийн хүрээлэнгийн Ерөнхийлөгч Ким Жонгсүк • Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Фиона Блайт • Жендэрийн үндэсний хорооны жендэрийн шинжээч, Шархүүгийн Солонго <p>Чиглүүлэгч: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын Зөвлөх Боожоогийн Лакшми</p>
15:10 – 15:30	Асуулт, хариулт
15:30 – 16:00	Цайны завсарлага
<p>Сэдэвчилсэн хуралдаан 2: Хөдөөгийн хүн амын аж байдлыг сайжруулах, жендэрийн хариуцлагатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мэдлэгийн платформ</p>	
13:30 – 13:40	<p>Нээлтийн үг</p> <ul style="list-style-type: none"> • УИХ-ын гишүүн Аюушийн Ариунзаяа
13:40 – 14:10	<p>Үндсэн илтгэл</p> <ul style="list-style-type: none"> • БНХАУ-ын Экологи, байгаль орчны яам, Байгаль орчны төлөвлөлтийн академийн ахлах мэргэжилтэн, Др. Гэ Чажон

14:10 – 15:10	<p>“Уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж буй бэлчээрийн мал ахуй, газар тариалангийн салбарт ажиллаж буй нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг анхаарсан шийдэл”</p> <ul style="list-style-type: none"> • Богино хэмжээний бичлэг (3 мин) <p>Зочин оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Эмэгтэйчүүдийн асуудал, гэр бүл, хүн ам зүйн бодлогын үндэсний комиссын гишүүн, Актобе мужийн их сургуулийн Ректор Карабасова Лаура Чапаевна • НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын Ази, Номхон далайн бүсийн газрын ахлах мэргэжилтэн Фатоу Жа • Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Др. Дугарын Сүнжид • Монгол Улсын ХААИС-ийн дэд проф., Др. Гончигсумлагийн Ганзориг <p>Чиглүүлэгч: Азийн хөгжлийн банкны Жендэрийн албаны Нийгмийн хөгжил, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Бэгзсүрэнгийн Цолмон</p>
15:10 – 15:30	Асуулт, хариулт
15:30 – 16:00	Цайны завсарлага
ЗЭРЭГЦЭЭ ХУРАЛДААН 1: (Сэдэвчилсэн хуралдаан 1, 2 зэрэг явагдана)	
Сэдэвчилсэн хуралдаан 3: Жендэрийн хариуцлагатай уур амьсгалын санхүүжилт	
16:00 – 16:10	<p>Нээлтийн үг</p> <ul style="list-style-type: none"> • УИХ-ын гишүүн Батбаярын Жаргалан
16:10 – 16:40	<p>Үндсэн илтгэл</p> <ul style="list-style-type: none"> • Уур амьсгалын ногоон сангийн Түншлэл, хөрөнгө босголт хариуцсан захирал Санжаасүрэнгийн Оюун (видео танилцуулга)

16:40 – 17:40	<p>“Жендэрийн хариуцлагатай уур амьсгалын санхүүжилтийн чиглэлд баримталж буй олон талын оролцоо, байр суурь”</p> <ul style="list-style-type: none"> • Богино хэмжээний бичлэг (3 мин) <p>Зочин оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү • Бүгд Найрамдах Филиппин Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн хорооны комиссар Рэйчел Анн С.Херрера • Азийн хөгжлийн банкны Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн газрын тэргүүлэх эдийн засагч Деклайн Мэги • Европын хөрөнгө оруулалтын банкны БНХАУ, Монгол Улс хариуцсан бүсийн төлөөлөгчийн газрын дарга Ауво Кайкконен <p>Чиглүүлэгч: Монголын Тогтвортой санхүүжилтийн холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал Энхбатын Ананд</p>
17:40 – 18:00	Асуулт, хариулт
<p>Сэдэвчилсэн хуралдаан 4: Эмэгтэйчүүдээр удирдуулсан уур амьсгалын санаачилга, эмэгтэйчүүдийн манлайллын чадамжийг таниулах нь</p>	
16:00 – 16:10	<p>Нээлтийн үг</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Тогтвортой хөгжлийн дэд хорооны дарга Баатаржавын Мөнхсоёл
16:10 – 16:40	<p>Үндсэн илтгэл</p> <ul style="list-style-type: none"> • НҮБ-ын Хүн амын сангийн Ази, Номхон далайн бүсийн дэд захирал Др. Александр Саша Бодироза

16:40 – 17:40	<p>“Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чиглэлээр гэр бүл, байгууллага, салбар, орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн санаачилж буй сайн туршлага, эмэгтэйчүүдийн манлайлал”</p> <ul style="list-style-type: none"> • Богино хэмжээний бичлэг (3 мин) <p>Зочин оролцогчид:</p> <ul style="list-style-type: none"> • Австрали Улсын Хөгжлийн бэрхшээл судлалын хүрээлэнгийн захирал Клэр Гибеллини • Канад Улсын “Алинеа Интернейшнл” байгууллагын Жендэрийн асуудал хариуцсан ахлах зөвлөх Кэтрин Хилл • Европын Холбооны санхүүжилттэй “Ойн засаглал ба нэмүү өртгийн сүлжээ” хөтөлбөрийн Ойн салбарын засаглал, худалдааны асуудал хариуцсан шинжээч Мария Пахта • “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ-ын Тэргүүн, үүсгэн байгуулагч Батхуягийн Золзаяа <p>Чиглүүлэгч: Монгол Улс дахь НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч Матилда Димовска</p>
17:40 – 18:00	Асуулт, хариулт
19:30 – 21:30	Хүндэтгэлийн хүлээн авалт (зөвхөн урилгаар)

2025 оны 5 дугаар сарын 23, Баасан гараг. Шангри-ла Улаанбаатар, Их танхим.

Хугацаа	Үйл ажиллагаа
08:00 – 09:00	Бүртгэл
09:00 – 09:10	Нээлтийн үг <ul style="list-style-type: none"> Монгол Улсын Ерөнхий сайдын Жендэрийн асуудал хариуцсан зөвлөх Чулуунбаатарын Болортуяа
09:10 – 09:20	Видео мэндчилгээ <ul style="list-style-type: none"> НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Гүйцэтгэх захирал Ингер Андерсен
09:20 – 09:35	Үндсэн илтгэл “Жендэрийн тэгш байдлыг хангах олон улсын зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмэр, ирээдүйн манлайлал” <ul style="list-style-type: none"> Монгол Улсын Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Төмөр-Өлзийн Энхбаяр
СЭДЭВЧИЛСЭН ХУРАЛДААНЫ ҮР ДҮН	
09:35 – 10:30	Сэдэвчилсэн хуралдааны гол үр дүнгийн танилцуулга <ul style="list-style-type: none"> 1-р хуралдааны модератор: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн жендэрийн хариуцлагатай бодлого 2-р хуралдааны модератор: Хөдөөгийн хүн амын аж байдлыг сайжруулах, жендэрийн хариуцлагатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мэдлэгийн платформ бий болгох 3-р хуралдааны модератор: Жендэрийн хариуцлагатай уур амьсгалын санхүүжилт 4-р хуралдааны модератор: Эмэгтэйчүүдийн манлайллын чадамж, уур амьсгалын өөрчлөлтийн талаар гаргасан санаачилга Чиглүүлэгч: Жендэрийн үндэсний хорооны Жендэр судлаач, Дэд проф., Др. Нарангийн Болдмаа
10:30 – 10:50	Оролцогчдын санал, сэтгэгдэл
10:50 – 11:20	Цайны завсарлага
УРИАЛГА	
11:20 – 11:40	Уриалгыг уншиж танилцуулах <ul style="list-style-type: none"> Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Цэцэгмаагийн Уртнасан
ХААЛТ	

11:40 – 12:10	Хаалтын үг: <ul style="list-style-type: none">• Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагч Яап ван Хиердэн (видео хаалтын үг)• Монгол Улсын Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Төмөр-Өлзийн Энхбаяр
---------------	---